



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2025/001/НА-СТА-ЗГТС

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор
2025 оны 03 дугаар сарын 25

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: М.Алтантуяа
Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
Ахлах аудитор: Н.Батчимэг
Утас: 91113253 Цахим хаяг: batchimegn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
4.5.1 Завсрын аудитын талаар.....	18
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДС	Нийгмийн даатгалын сан
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2025.03.25 № 2/92
танай _____-ны № _____-т

Хязгаарлалтай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдлийн тэтгэмж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг улсын хэмжээнд нэхэмжлэлд суурилсан Sicos программд шилжүүлэн бүртгэх ажилд удааширч аудитын хугацаанд Баянхонгор аймгийн тэтгэвэр авагч 13,069 иргэнд олгосон тэтгэврийн цахим нотлох баримт нь санхүүгийн тайлангийн дүнгээс зөрүүтэй байгаа нь шинж чанарын хувьд материаллаг бөгөөд санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Дээрх зөрчил нь Төрийн аудитын тухай 15 дугаар зүйлийн 15.1 дэх "Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ мэдээллээр бүрэн хангагдах зарчмын хүрээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 15.1.1 дэх "шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг хэлбэрээс нь үл хамааран шалгагдагч этгээд, аудитад хамрагдагч болон холбогдох бад байгууллага, албан тушаалтнаас тогтоосон хугацаанд, үнэ төлбөргүйгээр гаргуулах, хуулбарлаж авах", 15.1.5 дахь "энэ хуулийн 13.2-т заасан

5020438

системийн мэдээллийн санг бүрдүүлэх зорилгоор төрийн бусад байгууллагын цахим систем болон цахим хэлбэрээр бүрдүүлсэн мэдээллийн сангаас аудитад шаардлагатай мэдээллийг гаргуулах” гэсэн заалтыг зөрчсөн, УСНББОУС 29 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 дахь “Иж бүрэн байх”, “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийн хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Сангийн батлагдсан төсвөөс тайлант онд өндөр насны тэтгэвэрт 13,069 иргэнд 108,833,169.5 мянга, жирэмсэн амаржсаны тэтгэмжид 794 иргэнд 4,312,397.8 мянга, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжид 366 иргэнд 738,000.0 мянга, хөдөлмөрийн чадвараа алсаны тэтгэмжид 305 иргэнд 103,895.3 мянга, ажилгүйдлийн тэтгэмжид 491 иргэнд 1,349,222.0 мянга, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг 23 иргэнд 264,200.0 мянган төгрөгийг тус тус олгосон байна.

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	11,319,188,506.81	12,403,115,081.49
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	7,957,845,851.40	8,657,562,447.45
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	7,957,845,851.40	8,657,562,447.45
31210	Төгрөг	7,957,845,851.40	8,657,562,447.45
31213	Арилжааны банк дахь харилцах	7,957,845,851.40	8,657,562,447.45
33	АВЛАГА	3,361,342,655.41	3,745,552,634.04
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	1,997,318,582.57	0.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	1,322,505,167.63	1,321,898,167.63
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	0.00	2,364,879,618.26
33500	Бусад авлага	41,518,905.21	58,774,848.15
33510	Байгууллагаас авах авлага	41,518,905.21	22,003,798.17
33520	Хувь хүмүүсээс авах авлага	0.00	36,771,049.98
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	11,319,188,506.81	12,403,115,081.49
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	581,552,860.29	2,145,305,716.98
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	581,552,860.29	2,145,305,716.98
41300	Өглөг	52,063,142.70	1,122,108,733.53
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	52,063,142.70	0.00
41360	Бусад өглөг	0.00	1,122,108,733.53
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	458,334,598.23
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.00	644,094,813.81
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	0.00	19,679,321.49
41400	Урьдчилж орсон орлого	529,489,717.59	1,023,196,983.45
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	529,489,717.59	1,023,196,983.45
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,737,635,646.52	10,257,809,364.51
51	Засгийн газрын хувь оролцоо	10,737,635,646.52	10,257,809,364.51
51200	Хуримтлагдсан үр дүн	10,737,635,646.52	10,605,819,686.01
51210	Өмнөх үеийн үр дүн	10,350,410,868.02	10,737,635,646.52
51220	Тайлант үеийн үр дүн	387,224,778.50	-131,815,960.51
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	0.00	-348,010,321.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	11,319,188,506.81	12,403,115,081.49

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	164,494,351,559.23	159,793,771,272.44
11	ТАТВАРЫН ОРЛОГО	38,403,937,759.58	46,377,577,969.21
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	38,403,937,759.58	46,377,577,969.21
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	26,869,932,152.15	39,411,362,532.01
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,786,664,557.53	3,956,550,726.01
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,686,164,495.27	1,728,583,694.63
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	512,501,832.63	1,281,081,016.56
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	6,548,674,722.00	0.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	119,658,919.64	58,959,073.81
120	Нийтлэг татварын бус орлого	119,658,919.64	58,959,073.81
120002	Хүүгийн орлого	52,445,992.07	43,770,369.04
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,488,017.25	0.00

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,488,017.25	0.00
120009	Бусад орлого	55,724,910.32	15,188,704.77
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	125,970,754,880.01	113,357,234,229.42
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	8,361,899,432.19	16,811,958,179.42
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	8,361,899,432.19	16,811,958,179.42
1330	Төсвийн захирагчдаас	117,608,855,447.82	96,545,276,050.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	117,608,855,447.82	96,545,276,050.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	164,107,126,780.73	159,925,587,232.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	164,107,126,780.73	159,925,587,232.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,183,990.00	12,539,171.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,183,990.00	12,539,171.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	4,282,761.50
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	6,183,990.00	8,256,410.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	164,100,942,790.73	159,913,048,061.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	90,278,723,466.19	116,089,470,342.95
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	90,278,723,466.19	116,089,470,342.95
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	73,822,219,324.54	43,823,577,718.50
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	73,822,219,324.54	43,823,577,718.50
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	387,224,778.50	-131,815,960.51
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	387,224,778.50	-131,815,960.51

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	166,582,644,073.44	168,264,349,202.73
11	ТАТВАРЫН ОРЛОГО	37,978,941,651.55	52,127,009,189.04
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	37,978,941,651.55	52,127,009,189.04
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	26,584,320,831.48	37,382,538,460.37
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,754,960,602.43	3,916,625,140.90
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,665,795,501.13	1,737,053,929.87
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	504,802,012.12	1,261,349,106.42
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	6,469,062,704.39	7,829,442,551.48
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	518,611,274.07	43,834,163.69
120	Нийтлэг татварын бус орлого	518,611,274.07	43,834,163.69
120002	Хүүгийн орлого	46,523,481.47	43,834,163.69
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	472,087,792.60	0.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	472,087,792.60	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	128,085,091,147.82	116,093,505,850.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	10,476,235,700.00	19,548,229,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	10,476,235,700.00	19,548,229,800.00
1330	Төсвийн захирагчдаас	117,608,855,447.82	96,545,276,050.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	117,608,855,447.82	96,545,276,050.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	164,647,602,629.12	167,564,632,606.68

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

21	УРСГАЛ ЗАРДАЛ	164,647,602,629.12	167,564,632,606.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,183,990.00	12,539,171.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,183,990.00	12,539,171.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	4,282,761.50
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	6,183,990.00	8,256,410.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	164,641,418,639.12	167,552,093,435.18
2132	Бусад урсгал шилжүүлэг	90,819,199,314.58	115,600,884,566.33
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	90,278,723,466.19	115,600,884,566.33
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	540,475,848.39	0.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	73,822,219,324.54	51,951,208,868.85
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	73,822,219,324.54	51,951,208,868.85
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,935,041,444.32	699,716,596.05
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,935,041,444.32	699,716,596.05
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,022,804,407.08	7,957,845,851.40
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,957,845,851.40	8,657,562,447.45

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	10,351,329,722.01	10,351,329,722.01
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-918,853.99	-918,853.99
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	10,350,410,868.02	10,350,410,868.02
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	387,224,778.50	387,224,778.50
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	10,737,635,646.52	10,737,635,646.52
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	10,737,635,646.52	10,737,635,646.52
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-348,010,321.50	-348,010,321.50
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	10,389,625,325.02	10,389,625,325.02
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-131,815,960.51	-131,815,960.51
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	0.00	0.00	10,257,809,364.51	10,257,809,364.51

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	115,789,523,300.00	115,613,423,737.83	176,099,562.17	99.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	115,789,523,300.00	115,613,423,737.83	176,099,562.17	99.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	17,695,000.00	12,539,171.50	5,155,828.50	70.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,695,000.00	12,539,171.50	5,155,828.50	70.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,903,300.00	4,282,761.50	3,620,538.50	54.2
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	9,791,700.00	8,256,410.00	1,535,290.00	84.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	115,771,828,300.00	115,600,884,566.33	170,943,733.67	99.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	115,771,828,300.00	115,600,884,566.33	170,943,733.67	99.9
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	115,771,828,300.00	115,600,884,566.33	170,943,733.67	99.9
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	115,789,523,300.00	63,845,796,437.56	51,943,726,862.44	55.1
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	17,159,495,900.00	19,548,229,800.00	-2,388,733,900.00	113.9
310001	Улсын төсвөөс санхүүжих	17,159,495,900.00	19,548,229,800.00	-2,388,733,900.00	113.9
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	98,630,027,400.00	44,297,566,637.56	54,332,460,762.44	44.9
330001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	98,630,027,400.00	44,297,566,637.56	54,332,460,762.44	44.9
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	7,957,845,851.40	-7,957,845,851.40	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	8,657,562,447.45	-8,657,562,447.45	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын сан нь "Бид даатгуулагчийнхаа итгэл, найдвар, сэтгэл ахнамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэнэ" гэсэн эрхэм зорилготой үндсэн 44 орон тоотой үйл ажиллагаа явуулсан байна.

Сангийн батлагдсан төсвөөс тайлант онд өндөр насны тэтгэвэрт 13,069 иргэнд 108,833,169.5 мянга, жирэмсэн амаржсаны тэтгэмжид 794 иргэнд 4,312,397.8 мянга, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжид 366 иргэнд 738,000.0 мянга, хөдөлмөрийн чадвараа алсаны тэтгэмжид 305 иргэнд 103,895.3 мянга, ажилгүйдлийн тэтгэмжид 491 иргэнд 1,349,222.0 мянга, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг 23 иргэнд 264,200.0 мянган төгрөгийг тус тус олгосон байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Нийгмийн даатгалын газрын дарга Б.Азжаргал, 2 дугаар гарын үсгийг Санхүү бүртгэл, хамралт, орлогын хэлтсийн дарга, ахлах нягтлан бодогч С.Хонгорзул нар зурсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын ерөнхий хууль
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль
- Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль
- НДЕГ-ын даргын 2024.12.20-ны өдрийн “Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг батлах тухай” А/243 дугаар тушаал

Дээрх хуулиад нь шинэчлэн найруулагдаж 2023.07.07-ны өдөр батлагдаж 2024.01.01-ний өдрөөс дагаж мөрдсөн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сангийн үйл ажиллагаанд мөрдөж буй НДЕГ-ын даргын 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/64 дүгээр тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус сангийн үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайланг УСНББОУС-1 стандартын дагуу бэлтгэсэн байна. Тайлант онд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 12,403,115.08 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 1.083.926.58 мянган төгрөгөөр буюу 10.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	11,319,188.50	12,403,115.08	1,083,926.58
Мөнгөн хөрөнгө	7,957,845.85	8,657,562.44	699,716.59
Авлага	3,361,342.65	3,745,552.63	384,209.98
Нийт хөрөнгө	11,319,188.50	12,403,115.08	1,083,926.58
Өр төлбөр	581,552.86	2,145,305.71	1,563,752.85
Урьдчилж орсон орлого	529,489.71	1,023,196.98	493,707.27
Засгийн газрын хувь оролцоо (Эздийн өмч)	10,737,635.64	10,605,819.68	131,815.96
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	11,319,188.50	12,403,115.08	1,083,926.58

Эх сурвалж: НДС-ийн 2024 оны санхүүгийн тайлан

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 7,957,845.85 мянга, эцсийн үлдэгдэл 8,657,562.44 мянган төгрөг болж 699,716.59 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Арилжааны банкны үлдэгдлийн 96.9 хувь буюу 8,391,233.5 мянган төгрөг нь тэтгэврийн даатгалын сан байгаа нь дараа сарын тэтгэвэрийг олгохоор санхүүжилтийг өмнөх сард олгосонтой холбоотой байна.

Төвлөрсөн санд оны эцэст интернет банкаар гүйлгээ орсноос шалтгаалж, оны эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 2. Арилжааны банкны дансны үлдэгдэл (мянган төгрөгөөр)

Банк	Төвлөрсөн харилцах	Тэтгэвэр	Тэтгэмж	ҮОМШӨ	Ажилгүйдэл	Дүн
Голомт банк	-	675,839.2	-	-	-	675,839.2
Төрийн банк	10,563.8	2,862,600.1	49.0	6,001.4	13.4	2,879,277.7
Хаан банк	220,024.8	4,852,794.2	2,949.5	26,638.2	88.9	5,102,495.5
Дүн	230,588.6	8,391,233.5	2,998.5	32,639.6	102.3	8,657,562.5

Эх сурвалж: Арилжааны банкны дансны хуулга

Арилжааны банкинд байршиж байгаа мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс харахад нийт үлдэгдлийн 58.9 хувь буюу 5,102,495.5 мянган төгрөг нь хаан банкинд, 33.3 хувь буюу 2,879,277.7 мянган төгрөг нь төрийн банкинд, 7.8 хувь буюу 675,839.2 мянган төгрөг нь голомт банкинд байршсан байна.

Тайлант онд хаан банк 28,366.4 мянга, төрийн банк 13,425.6 мянга, хас банк 43.2 мянга, голомт банк 1,999.9 мянга нийт 43,834.2 мянган төгрөгийн хүүгийн орлого орсон байна.

3.4.2 Авлага

Оны эхний 3,361,342.7 мянган төгрөгийн авлага 384,209.9 мянган төгрөгөөр өсч оны эцэст 3,745,552.6 мянган төгрөгийн авлагатай гарчээ.

Хүснэгт № 3. Авлагын үлдэгдэл

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төлбөртэй үйлчилгээний авлага	1,997,318.6	0.0	-1,997,318.6
Татвар, НДШ-ийн авлага	0.0	2,364,879.6	2,364,879.6
Татаас санхүүжилтийн авлага	1,322,505.2	1,321,898.2	-607.0
Бусад авлага-Байгууллага	41,518.9	22,003.8	-19,515.1
Бусад авлага-Хувь хүн	0.0	36,771.0	36,771.0
Дүн	3,361,342.7	3,745,552.6	384,209.9

Эх сурвалж: НДС-ийн 2024 оны санхүүгийн тайлан

Нийт авлагын 63.1 хувь буюу 2,364,879.6 мянган төгрөг нь ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн авлага, 35.3 хувь буюу 1,321,898.2 мянган төгрөг нь татаас санхүүжилтийн авлага, 0.6 хувь буюу 22,003.8 мянган төгрөг нь байгууллагаас авах авлага, 1.0 хувь буюу 36,771.0 мянган төгрөг нь хувь хүнээс авах авлага байна.

Татаас, санхүүжилтийн авлага өмнөх оноос 607.0 мянган төгрөгөөр буурч 1,321,898.2 мянган төгрөг болсон нь Коронавирус халдвар 2020 онд гарснаас шалтгаалан үйл ажиллагаа нь доголдож, орлого нь буурсан хэдий ч ажлын байрыг хадгалж, хуульд заасан хугацаанд НДШ төлөлтийн тайлан ирүүлсэн хуулийн этгээдэд ажиллаж байгаа даатгуулагчаас бусад даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод ногдуулсан ажил олгогч болон даатгуулагчийн 2020 он 4-10 дугаар саруудын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү орлогод тэтгэвэр, тэтгэмж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг чөлөөлснийг тайлант онд улсын төсвөөс олгосонтой холбоотой тус авлага буурсан байна.

НДЕГ-ын даргын 2024.12.20-ны өдрийн “Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг батлах тухай” А/243 дугаар тушаалаар өөрчлөлт орсоноор төлбөртэй үйлчилгээний авлагаар бүртгэдэг байсан авлагыг татвар, НДШ-ийн авлага, бусад авлага-хувь дансанд бүртгэсэн байна.

3.4.3 Өр төлбөр

Өр төлбөр дансны эхний үлдэгдэл 581,552.9 мянга, эцсийн үлдэгдэл 2,145,305.7 мянган төгрөг болж, 1,563,752.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт № 4. Өр төлбөрийн үлдэгдэл

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бараа үйлчилгээний өглөг	52,063.1	0.0	-52,063.1
Байгууллагад төлөх өглөг	0.0	458,334.6	458,334.6
Хувь хүмүүст төлөх өглөг	0.0	644,094.8	644,094.8
Бусад өглөг	0.0	19,679.3	19,679.3
Урьдчилж орсон орлого	529,489.7	1,023,197.0	493,707.3
Дүн	581,552.8	2,145,305.7	1,563,752.9

Эх сурвалж: НДС-ийн 2024 оны санхүүгийн тайлан

Нийт өр төлбөрийн 21.4 хувь буюу 458,334.6 мянган төгрөг нь байгууллагад төлөх өглөг, 30.0 хувь буюу 644,094.8 мянган төгрөг нь хувь хүмүүст төлөх өглөг, 0.9

хувь буюу 19,679.3 мянган төгрөг нь дансны өглөг, 47.7 хувь буюу 1,023,197.0 мянган төгрөг нь урьдчилж орсон орлого байна.

НББББ-т өөрчлөлт орсоноор зээл, зээлийн хүүгийн өглөгөөс бусад өглөгийг “Бусад өглөг” дансанд бүртгэсэн бол урьдчилж орсон орлого дансанд сар бүрийн эцэст НДШ-ийн авлага данс ба урьдчилж орсон НДШ-ийн орлого дансыг хооронд нь хааж хаагдаагүй үлдэгдлийн дүнгээр санхүү байдлын тайланд богино хугацаат өр төлбөрөөр тайлагнасан байна.

3.4.4 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 10,737,635.6 мянга, эцсийн үлдэгдэл 10,605,819.7 мянган төгрөг болж 131,816.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус санд 2024 онд нийт орлогыг 35,551,475.9 мянга, нийт зарлагыг 113,584,224.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тэтгэврийн нэмэгдэлтэй холбоотойгоор төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 5 удаа тодотгон Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024.12.19-ний өдрийн “Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн сарын хуваарьт өөрчлөлт оруулах тухай” А/240 дүгээр тушаалаар анх батлагдсан төсвөөс орлогыг 5,578,024.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн нийт орлогыг 43,321,522.2 мянга, нийт зардлыг 115,781,620.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт № 5. Батлагдсан төсөв

(мянган төгрөгөөр)

Орлогын төрөл	Төсвийн төсөл	Анх батлагдсан төсөв	Тодотгон баталсан төсөв
Аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогчийн төлөх шимтгэл	4,816,360.5	14,749,309.4	18,817,920.8
Даатгуулагчийн төлөх шимтгэл	13,304,941.2	13,225,372.9	14,734,786.4
Төсөвт байгууллагаас төлөх шимтгэл	9,141,770.1	0.0	0.0
Сайн дурын даатгуулагчдын төлөх шимтгэл	7,966,775.0	7,003,326.7	7,003,326.7
Эхийн хүүхэд асрах чөлөөтэй хугацааны тэтгэмжийн сангаас төлөх шимтгэл	175,312.5	322,280.2	322,280.2
Эхийн хүүхэд асрах чөлөөтэй хугацааны улсын төсвийн төлөх шимтгэл	134,062.5	270,612.4	270,612.4
Бусад орлого	12,254.1	40,345.1	40,345.1
Малчин хувиараа хөтөлбөр эрхлэгчийн сайн дураар төлөх шимтгэл	0.0	1,881,257.4	1,881,257.4
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эцэг эхийн шимтгэл	0.0	236,864.1	236,864.1
ҮОМШӨ-ний уламаас тахир дутуу болсон даатгуулагчийн шимтгэл	0.0	14,129.1	14,129.1
Нийт дүн	35,551,475.9	37,743,497.3	43,321,522.2

Эх сурвалж: НДС-ийн 2024 оны төсвийн төсөл, батлагдсан төсөв

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант 2024 онд нийт 43,321,522.2 мянган төгрөгийн орлого оруулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 51,403,058.2 мянган төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрч орлогын төлөвлөгөөг 118.7 хувь 8,081,536.0 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны зардлыг 115,781,620.0 мянган төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 115,600,884.6 мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийг олгосон байна.

Хүснэгт 6. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

(мянган төгрөгөөр)

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Тэтгэврийн даатгалын сан	109,249,160.5	108,833,169.5	415,991.0	99.6
2	Тэтгэмжийн даатгалын сан	5,085,661.6	5,154,293.1	-68,631.5	101.3
3	ҮОМШӨ-ний даатгалын сан	416,151.3	264,200.0	151,951.3	63.5
4	Ажилгүйдлийн даатгалын сан	1,030,646.6	1,349,222.0	-318,575.4	130.9
ДҮН		115,781,620.0	115,600,884.6	180,735.4	99.8

Эх сурвалж: НДС-ийн 2024 оны төсвийн хэлбэлзэл

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Батчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01/136 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны нийт

зардал 115,789,523.3 мянган төгрөгийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нийт зардал 115,789,523.3 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 578,947.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 55 хувиар буюу 318,421.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуульд хамаарах асуудал байхгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны хэрэгжилтэд НДЕГ-аас аудит хийж 161,518.0 мянган төгрөгийн 5 мэдээллийг мэдээлээгүй байсныг илрүүлэн зөрчлийг арилгасан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант хугацаанд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэсэн ба сантай холбоотой алдаа, зөрчил илрээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдлийн тэтгэмж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг улсын хэмжээнд нэхэмжлэлд суурилсан Sicos программд шилжүүлэн бүртгэх ажил хийгдэж Баянхонгор аймгийн тэтгэвэр авагч 13,069 иргэний тэтгэврийг тус программд бүрэн оруулаагүйгээс аудитын хугацаанд тулгалт хийгдээгүй тул

дараагийн аудитаар эхний үлдэгдлийг зайлшгүй тулган баталгаажуулах шаардлагатай.

2. НББББ-ын өөрчлөлтөөс шалтгаалан Санхүү байдлын тайланд тусгагдсан бодлогын өөрчлөлт алдааны залруулга 348,010.3 мянган төгрөгийг дараагийн санхүүгийн тайлангийн аудитаар устгах бичилт хийгдсэн эсэхийг шалгах шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдлийн тэтгэмж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг улсын хэмжээнд нэхэмжлэлд суурилсан Sicos программд шилжүүлэн бүртгэх ажилд удааширч аудитын хугацаанд Баянхонгор аймгийн тэтгэвэр авагч 13,069 иргэнд олгосон тэтгэврийн цахим нотлох баримт нь санхүүгийн тайлангийн дүнгээс зөрүүтэй байгаа нь шинж чанарын хувьд материаллаг бөгөөд санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----oOo-----